

Үнэлгээний хорооны хуралдааны тойм

Өвөрхангай аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газраас зарлагдсан ӨВАХААГ/20260102033/01/01 урилгын дугаартай 120.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэй Хөдөө аж ахуйн салбарын хаваржилтийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 10.000 боодол нарийн ногоон өвс худалдан авах ажлын тендер шалгаруулалтад 2 аж ахуйн нэгж материалаа цахимаар ирүүлснийг 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн үнэлгээний хорооны хуралдаанаар хянан хэлэлцэж хамгийн сайн тендер ирүүлсэн “ТҮЙН ГОЛЫН ТӨГӨЛ” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн байна.

Д/Д	Худалдан авах бараа, ажил үйлчилгээ санхүүжилтийн эх үүсвэр	Оролцогч	Үнийн санал	Үр дүн	Тайлбар
1.	Хөдөө аж ахуйн салбарын хаваржилтийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 10.000 боодол нарийн ногоон өвс худалдан авах (Төсөвт өртөг 120.000.000)	“ТҮЙН ГОЛЫН ТӨГӨЛ” ХХК	109.000.000	Шалгарсан	Хамгийн сайн тендер ирүүлсэн.
		“БОР ЗАЛААН ЖИНЧИН” ХХК	118.000.000	Шалгараагүй.	2023, 2024 онуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь хэсэгт заасны дагуу Хүүхэд хамгааллын бодлого, Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох бараа нийлүүлэх гэрээ, эрх бүхий байгууллагын ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт, захиалагч эсвэл ашиглагчийн тодорхойлолт, Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар үзүүлэлт тус бүрээр хүснэгтээр бэлтгэж баталгаажуулах, Оролцогч нь байгууллагын банкн дахь дансны бэлэн мөнгө болон бусад валютын үлдэгдлийн тодорхойлолт /дансны хуулга нь банкны ажилтаны гарын үсэг, тамга, тэмдэгээр баталгаажуулж ирүүлэх/ мөн арилжааны банкнаас олгох зээлийн мөнгөн дүн бүхий тодорхойлолт зэргийг тус тус ирүүлээгүй байна.